



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2023 оны ээлжит 08 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаан 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр болов.

Энэхүү хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2017 оны 32 тоот тогтоол); “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай (Хорооны 2017 оны 31 тоот тогтоол); “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын төслийн тухай танилцуулга; “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-нд өөрчлөлт оруулах тухай танилцуулга; Харилцаа холбооны үйлчилгээ буюу интернэт, яриа, олон суваг дамжуулах болон интернэт протоколд суурилсан үйлчилгээний зах зээлийн нөхцөл байдлын судалгаа, дүгнэлтийн тухай; ХХЗХ-ны эд хөрөнгийг дахин үнэлэх ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлтийн тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт); “ХХЗХ-ны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга; Бусад: Хорооны гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан бичгийн тухай танилцуулга (2023 оны 44 тоот тогтоолын тухай) зэрэг нийтдээ 10 гаруй асуудлыг тус тус хэлэлцэн зохицуулах хорооны 16 тогтоолыг баталсан болно.

ХХЗХ-ны 2017 оны 32 тоот тогтоол, уг тогтоолын хавсралтаар “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 8 дугаар 28-ны өдрийн 3783 дугаарт бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. Уг баримт бичгийг баталсан хуулийн үндэслэлд 2019 онд өөрчлөлт оруулсан (Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.10 заалт), Радио давтамжийн 10 ГГц-ээс доош цараанд 1067 МГц-ийн зурвас нь бусад төрлийн радио холбооны үйлчилгээний нөхцөл шаардлагатай давхардал үүссэн; Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 тушаалаар “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нэмэлт өөрчлөлт оруулан батлагдсан тул “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” баримт бичгийг дээрх хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэх, уялдуулах, шинэчлэн батлах шаардлага үүссэн юм. Баримт бичгийн төслийг ажлын хэсгээс боловсруулж, яам байгууллагаас албан тоот, цахим хуудаст байршуулан саналыг авах, уулзалт хэлэлцүүлгийг 2023 оны 4-5 дугаар сард зохион байгуулсан. Радио давтамж зохицуулалт, хяналтын газраас “Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” танилцуулга, шийдвэрийн төсөл, тогтоолын хавсралт болох “Радио релейнд ашиглах

радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ын төсөл, уулзалт хэлэлцүүлэг, саналыг тусгасан товчоо судалгаа, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг боловсруулан зохицуулах хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 72 тоот "Радио релейнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай" тогтоолыг хавсралтын хамт батлав. Энэхүү баримт бичиг нь Дэлхийн радио холбооны дүрэм, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт болон Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup>.1.2 заалтыг тус тус үндэслэн радио релейнд ашиглах радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлсон. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан мөрдөж байсан тус хорооны 2017 оны 32 дугаар тогтоолыг хүчингүй болгов. Уг тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

Зохицуулах хорооны 2017 оны 31 тоот тогтоолоор "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ыг тогтоож, хавсралтаар баталсан бөгөөд ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 8 дугаар 28-ны өдрийн 3782 дугаарт хянуулан бүртгүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү тогтоолын хуулийн үндэслэлд 2019 онд өөрчлөлт оруулсан (Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.10 заалт), радио давтамжийн зурвас, техникийн нөхцөлүүд нь ОУЦХБ-аас гаргасан 25-3000 МГц-ийн радио давтамжийн зурваст ажиллах FM модуляцтай, газрын хөдөлгөөнт үйлчилгээний тоног төхөөрөмжийн техникийн онцлог, зарчим. (ITU-R M.478-5, 1995) зөвлөмж, Тоон газрын хөдөлгөөнт системүүд. (ITU-R M.2014-3, 2014) тайлан, Уламжлалт тоон газрын хөдөлгөөнт радио системүүд. (ITU-R M.2474-0, 2019) тайлан, Радио давтамжийн 960 МГц-ээс хамтран ашиглаж байгаа, 869 МГц-ээс доош үүрэн холбооны үйлчилгээнд ажилладаг уламжлалт болон транкд газрын хөдөлгөөнт системийн техникийн болон ашиглалтын характеристик. (ITU-R M.1808-1, 2019) зэрэг зөвлөмж, тайлангийн баримт бичгүүд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 тушаалаар "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт"-ийг баталсан зэрэг нь уг баримт бичгийг шинэчлэн батлах, хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага гарсан болно. Ажлын хэсгээс боловсруулсан "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага"-ын шинэчилсэн төслийг холбогдох яам, эрх ашиг нь хөндөгдөж байгаа ААН, хуулийн этгээд нарт албан тоотоор хүргүүлж, байгууллагын цахим хуудаст байршуулан санал авсан ба ХХЗХ-ноос 2023 оны 06 дугаар сард зохион байгуулсан радио тоног төхөөрөмж худалдан борлуулагч болон барилга угсралт, харуул хамгаалалт, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудын "Радио тоног төхөөрөмж худалдан борлуулагч болон эрхийн бичиг эзэмшигч нарт хууль эрх зүй, нөхцөл шаардлага журмын талаарх сургалт" сэдэвт уулзалт, сургалтад хэлэлцүүлсэн болно. Тус хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд "Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлагыг шинэчлэн батлах тухай" танилцуулга, тогтоолын төсөл, тогтоолын хавсралт баримт бичгийн төсөл, уулзалт хэлэлцүүлэг, ирүүлсэн саналыг тусгасан саналын товчоо, хуулийн нөлөөллийн шинжилгээг зэрэг баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлсэн. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Харилцаа

холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг шинэчлэн батлах тухай” 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 73 тоот тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэв. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан “Харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-аар Дэлхийн радио холбооны дүрэм, Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт болон Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup>.1.2 заалтыг тус тус үндэслэн харилцааны радио станцад ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагыг тодорхойлжээ. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2017 оны 31 дүгээр тогтоол, 2018 оны 18 дугаар тогтоол, 2019 оны 09 дүгээр тогтоол болон 2020 оны 70 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгоод байна. Энэхүү тогтоолыг хавсралтын хамт ХЗДХЯ-ны Захиргааны хэм, хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын бүртгэлд хянуулан шинээр бүртгүүлэхээр ХХЗХ-ны Даргын албан тоотоор хүргүүлээд байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол Улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл (*ХХМТГ-ын Даргын 2020 оны А/45 дугаар тушаал*)-ийг хэрэгжүүлэх, Монгол Улсад 5G Дараа үеийн хөдөлгөөнт холбооны систем нэвтрүүлэх бодлогын хүрээнд зохицуулалтын баримт бичгийг боловсруулах, боловсронгуй болгох; улмаар ЦХХХЯ-наас 2023 онд баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-д нийцүүлэх ажлын хүрээнд тус хорооны РДЗХГ-аас “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг шинэчлэх төслийг боловсруулан эрх ашиг нь хөндөгдөж байгаа байгууллага, хуулийн этгээд нартай уулзалт, хэлэлцүүлэг хийж байна. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд РДЗХГ-аас дээрх ажлын явц болон “Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын баримт бичгийн төсөл, албан тоот болон уулзалт, хэлэлцүүлгийн үеэр ирүүлсэн санал, зөвлөмжийг тусгасан эсэх үндэслэл, саналын товчоо зэрэг мэдээлэл, танилцуулгыг хэлэлцээд, хорооны Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, баримт бичгийн төслийг эцэслэн Хорооны хуралдаанд 2023 оны 08 дугаар сард багтаан хэлэлцүүлж, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг РДЗХГ, ажлын албанд үүрэг чиглэл болгов.

ХХЗХ-ны 2020 оны 71 тоот тогтоолоор “Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г тогтоож баталсан, энэхүү тогтоолыг ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 5272 дугаарт бүртгүүлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2023 онд баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”-ийг баталж, оруулсан өөрчлөлтөөр 3300-4200 Мгц-ыг Дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5G үйлчилгээнд зориулан хуваарилсан; мөн тус яамнаас 2022 онд баталсан “Радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журам”-д радио давтамжийн зурвасын өргөнийг 1 Мгц-ийн цараагаар тооцох, Эрхийн төлбөр тогтоох эрхийг Зохицуулах хороонд олгохоор журамласан, Радио релейн, радио линкний станцад ашиглах радио давтамжийн зурвас ашиглалтын төлбөрийг 6 цараанд хуваах болсон; Олон улсын цахилгаан холбооны байгууллагын зөвлөх үйлчилгээний “Монгол улсын Радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөрийн хэмжээнд хийсэн судалгааны

тайлан"-д Үүрэн хөдөлгөөнт холбооны станцын радио зурвасын ашиглалтын төлбөрийн хэмжээг үйлчилгээний төрлөөс хамааруулан ялгавартай тогтоож болохгүй гэсэн зөвлөмж зэргийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хорооны 2020 оны 71 тоот тогтоолоор "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-нд өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулах ажлын хэсгийг ЗЗҮТЗГ, РДЗХГ-ын ажлын албаны хамтарсан бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит 08 дугаар хуралдаанаар "Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-нд өөрчлөлт оруулах тухай танилцуулга, уулзалт хэлэлцүүлэг болон албан тоотоор ирүүлсэн санал, эрх ашиг нь хөндөгдөж байгаа нэр бүхий 7 компанийн удирдлагатай ажлын хэсгийн хийсэн уулзалтын үр дүн, саналын товчооны танилцуулгыг сонсов. Хуралдаанаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа ААН, хуулийн этгээд нартай уулзалт зохион байгуулах, Даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэх, баримт бичгийн төслийг Дараагийн Хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэгт даалгав.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн ээлжит 08 дугаар хуралдаанаар ажлын хэсгээс боловсруулсан "ХХЗХ-ны эд хөрөнгийг дахин үнэлэх ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлтийн тухай" танилцуулга, тогтоолын төсөл, эд хөрөнгийг дахин үнэлсэн санал дүгнэлт, хавсралт жагсаалт, ажлын хэсгийн хурлын шийдвэр, холбогдох материалыг авч хэлэлцэв. Энэхүү хэлэлцсэн асуудлаар, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", Харилцаа холбооны зохицуулах хорооны Өмч хамгаалах байнгын комиссын 2023 оны 01 дүгээр хурлын шийдвэр болон 2023 оны хагас жилийн эд хөрөнгийг тоолсон ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 74 тоот "Үндсэн хөрөнгө дахин үнэлэх саналын тухай" тогтоолыг 4 хавсралтын хамт батлав. Тогтоолд, тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад дурдсан 69 (жаран ес) нэр төрлийн 37,580,574 (гучин долоон сая таван зуун наян мянга таван зуун далан дөрөв) төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан ч цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой тавилга эд хогшлыг дахин үнэлж 14,731,529.60 (арван дөрвөн сая долоон зуун гучин нэгэн мянга таван зуун хорин есөн төгрөг жаран мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт; тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтад дурдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан ч цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой 99 (ерэн ес) нэр төрлийн 1,264,588,115.54 (нэг тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая таван зуун наян найман мянга нэг зуун арван таван төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй машин тоног төхөөрөмжийг дахин үнэлж 519,038,285.84 (таван зуун арван есөн сая гучин найман мянга хоёр зуун наян таван төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт; тус хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй энэхүү тогтоолын гуравдугаар хавсралтад дурдсан 24 (хорин дөрөв) нэр төрлийн 343,947,595.07 (гурван зуун дөчин гурван сая есөн зуун дөчин долоон мянга таван зуун ерэн таван төгрөг долоон мөнгө) төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан ч цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой программ хангамжийг дахин үнэлж 163,664,950.70 (нэг зуун жаран гурван сая зургаан зуун жаран дөрвөн мянга есөн зуун тавин төгрөг далан

мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоох хүсэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус тавьж шийдвэрлүүлэх; тус хорооны Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсэд бүртгэлтэй энэхүү тогтоолын дөрөвдүгээр хавсралтад дурдсан ашиглалтын хугацаа дууссан, цаашид хэвийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй 62 (жаран хоёр) нэр төрлийн 9,353,070 (есөн сая гурван зуун тавин гурван мянга дал) төгрөгийн бараа материалыг хасаж актлах, устгах саналыг зөвшөөрөв.

Харилцаа холбооны үйлчилгээ буюу интернэт, яриа, олон суваг дамжуулах болон интернэт протоколд суурилсан үйлчилгээний зах зээлийн нөхцөл байдлын судалгаа, дүгнэлтийн тухай танилцуулгыг хэлэлцээд, бүтцийн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд энэхүү судалгааны чиглэл бүрээр гарсан үр дүн, дүгнэлтүүд болон зах зээл, өрсөлдөөний байдлыг аливаа зохицуулалтын баримт бичиг, шийдвэрийг боловсруулахдаа харгалзан тооцох, уялдаа холбоог хангах, ашиглах, хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллахыг зөвлөмж болгов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 03 дугаар хуралдаанаар “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг Зөвшөөрлийн тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Мэдээллийн технологийн багц хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулгыг хорооны даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандахаас боловсруулан хэлэлцүүлсэн бөгөөд тус хуралдаанаас Хорооны гишүүн А.Лувсан-Очир, Хуулийн хэлтсийн дарга Т.Ууганбат, Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга Т.Наранмандах нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн байгуулахаар тогтож, хуралдааны дэгийн асуудлыг боловсруулан хуралдаанд хэлэлцүүлэхийг даалгасан юм. Зохицуулах хорооны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанд ажлын хэсгээс боловсруулсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны дэг”-ийг шинэчлэн батлах тухай танилцуулга, тогтоолын төсөл, хавсралтын хамт танилцуулгыг хэлэлцүүлэв. Тус хуралдаанаас энэхүү асуудлыг Хорооны дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгохоор тогтов.

Тус хуралдааны хэлэлцсэн бусад асуудлын хүрээнд Хорооны дарга, гишүүдэд ОНДО ХХК-иас ирүүлсэн албан бичгийн талаар танилцуулга (2023 оны 44 тоот тогтоолын тухай)-ыг сонсож, тус компаниас ирүүлсэн тоотод заасан хууль эрх зүйн үндэслэл, тайлбар мэдээллийг боловсруулан холбогдох байгууллагад гаргаж өгөх, хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд Хорооны дарга, гишүүдийг мэдээллээр хангах болон Хорооны хуралдаанд авсан арга хэмжээ, үр дүнг тухай бүр танилцуулан ажиллахыг РДЗХГ, Хуулийн хэлтэс-т тус тус даалгав.

ХХЗХ-ны 2023 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (-ТЗ шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; - Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг сунгах тухай үнэлгээ, дүгнэлт) газар хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 13 тогтоол, хавсралтын төслийг тус тус авч хэлэлцээд, тус хуралдаанаас 13 тогтоолыг хавсралтын хамт баталсан. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын

04-ний өдрийн 75 тоот тогтоолоор 1 хуулийн этгээд (Старлинк сервисес Монголиа ХХК)-д 1 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалт, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 76 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 77 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 78 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 3 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 79 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 80 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний 3 дугаар ашиглалтын хугацааг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Зэүс солюшнс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 81 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт болон Батжина трейд ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 82 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Керри глобалинк монгол ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 83 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Рийч традэко Жи Би ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 84 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Бид монгол интернэшнл ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 85 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Америк тээвэр ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 86 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт болон Амекс Эм Эн Жи ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 87 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэсэн.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2023-07-05